



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/337/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц. Хосжаргал
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б. Энхжин
Утас: 261628 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК
Захирал: Д. Ариунаа
Цахим хаяг: AriFin.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Төлбөрийн акт.....	14
4.2 Албан шаардлага.....	14
4.3 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Б. ЭЛБЭГСАЙХАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/338
танай _____-ны № _____-г
Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Оюуны өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Оюуны өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх онд 73,989.1 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөр олгосон бараа, ажил үйлчилгээний гэрээний актыг дүгнээгүй, ажлын гүйцэтгэлийн баримт дутуу, анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу 49,441.4 мянган төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд тайлагнасан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:...16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	132,881,077.04	91,334,979.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,851,280.00	24,035,680.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	2,851,280.00	24,035,680.00
3121	Төгрөг	2,851,280.00	24,035,680.00
31211	Төрийн сангийн харилцах	2,851,280.00	24,035,680.00
34	УРЬДЧИЛГАА	73,989,073.00	60,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	73,989,073.00	60,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	56,040,724.04	67,239,299.04
351	Түүхий эд материал	9,713,500.00	12,930,580.00
35110	Тусгай зориулалттай материал	9,713,500.00	12,930,580.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	22,039,649.00	10,515,719.00
354	Хангамжийн материал	24,287,575.04	43,793,000.04
35410	Бичиг хэргийн материал	2,202,663.00	7,669,142.00
35420	Аж ахуйн материал	17,748,675.04	28,996,034.04
35440	Түлш, шатах тослох материал	3,523,000.00	4,197,980.00
35470	Бусад хангамжийн материал	813,237.00	2,929,844.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	544,846,806.12	930,731,680.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	544,846,806.12	930,731,680.64
392	Биет хөрөнгө	460,624,639.42	796,157,002.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	172,700,000.00	172,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-40,774,166.78	-56,144,166.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	912,674,942.00	1,229,947,210.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-684,006,248.79	-654,720,761.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	189,815,155.70	168,422,417.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-89,785,042.71	-64,047,696.35
393	Биет бус хөрөнгө	84,222,166.70	134,574,678.48
39301	Программ хангамж	297,923,964.00	181,318,809.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-213,701,797.30	-46,744,130.52
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	677,727,883.16	1,022,066,659.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	677,727,883.16	1,022,066,659.68
51	Засгийн газрын хувь оролцоо	677,727,883.16	1,022,066,659.68
512	Хуримтлагдсан үр дүн	677,727,883.16	1,022,066,659.68
51210	Өмнөх үеийн үр дүн	677,727,883.16	677,787,883.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	344,278,776.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	677,727,883.16	1,022,066,659.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,733,767,162.70	1,813,205,253.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,131,007,669.00	1,639,323,058.55
120	Нийтлэг татварын бус орлого	1,131,007,669.00	1,639,323,058.55
120003	Торгуулийн орлого	00.00	24,035,650.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,126,556,400.00	1,615,287,408.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,126,556,400.00	1,615,243,408.55

Оюуны өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	44,000.00
120009	Бусад орлого	2,851,280.00	00.00
120018	Үнэ төлбөргүй авсан орлого-Бараа материал	1,599,989.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	602,759,493.70	173,882,195.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	180,000,000.00	170,582,195.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	180,000,000.00	170,582,195.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	422,759,493.70	3,300,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,686,780.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	413,072,713.70	3,300,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,577,722,770.12	1,468,926,477.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,577,722,770.12	1,468,926,477.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,378,875,725.48	1,430,943,458.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,483,946.47	632,783,006.56
210101	Үндсэн цалин	334,143,299.13	429,212,183.56
210102	Нэмэгдэл	155,101,199.98	140,931,358.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,139,447.36	62,639,465.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,100,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,736,841.87	80,575,632.01
210201	Тэтгэврийн даатгал	56,788,299.87	57,898,860.07
210202	Тэтгэмжийн даатгал	1,796,455.00	5,823,609.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	639,400.00	4,616,433.88
210204	Ажилгүйдлийн даатгал	520,687.00	1,105,557.78
210205	Эрүүл мэндийн даатгал	7,992,000.00	11,131,170.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,505,800.00	242,665,300.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	35,445,300.00
210302	Түлш, халаалт	00.00	20,870,200.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	672,400.00
210304	Байрны түрээс	98,505,800.00	185,677,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,641,826.49	57,562,320.26
210401	Бичиг хэрэг	9,164,037.00	8,361,076.00
210402	Тээвэр, шатахуун	5,337,000.00	8,375,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,333,545.72	18,860,740.26
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,474,300.00	2,040,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,804,793.77	19,925,484.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,572,349.00	77,026,623.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,867,949.00	00.00
210604	Урсгал засвар	3,704,400.00	77,026,623.00
2107	Томилолт, зочны зардал	21,626,162.00	4,225,000.00
210701	Гадаад албан томилолт	13,500,000.00	4,018,000.00
210702	Дотоод албан томилолт	8,126,162.00	207,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	413,389,374.00	116,025,769.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	355,823,480.00	81,190,493.42
210803	Даатгалын үйлчилгээ	2,850,400.00	2,986,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,300.00	165,476.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,498,294.00	24,955,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	15,780.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,027,900.00	6,678,920.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	132,919,425.65	220,079,807.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	68,220,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,540,000.00	11,550,773.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	120,379,425.65	140,308,854.48
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	198,847,044.64	37,983,018.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,260,000.00	16,821,895.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	131,260,000.00	1,476,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	10,845,895.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	4,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,587,044.64	21,161,123.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,635,903.94	17,861,123.30
213305	Төвлөрүүлэг шилжүүлэг /нэмэлт санхүүжилт/	39,951,140.70	3,300,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	156,044,392.58	344,278,776.52
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,595,360.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,595,360.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-4,595,360.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	151,449,032.58	344,278,776.52

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			526,278,850.58	526,278,850.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			526,278,850.58	526,278,850.58
Тайлант үеийн үр дүн			151,449,032.58	151,449,032.58
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			677,727,883.16	677,727,883.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			60,000.00	60,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			677,787,883.16	677,787,883.16
Тайлант үеийн үр дүн			344,278,776.52	344,278,776.52
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			1,022,066,659.68	1,022,066,659.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,732,181,973.70	1,813,161,253.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,129,422,480.00	1,639,279,058.55
120	Нийтлэг татварын бус орлого	1,129,422,480.00	1,639,279,058.55

120003	Торгуулийн орлого	00.00	24,035,650.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,126,571,200.00	1,615,243,408.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,126,571,200.00	1,615,243,408.55
120009	Бусад орлого	2,851,280.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	602,759,493.70	173,882,195.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	180,000,000.00	170,582,195.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	180,000,000.00	170,582,195.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	422,759,493.70	3,300,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,686,780.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	413,072,713.70	3,300,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,561,010,193.70	1,265,783,124.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,561,010,193.70	1,265,783,124.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,362,163,149.06	1,227,800,106.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,322,246.47	632,783,006.56
210101	Үндсэн цалин	333,981,599.13	429,212,183.56
210102	Нэмэгдэл	155,101,199.98	140,931,358.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,139,447.36	62,639,465.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,100,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,736,841.87	80,575,632.01
210201	Тэтгэврийн даатгал	56,788,299.87	57,898,860.06
210202	Тэтгэмжийн даатгал	1,796,455.00	5,823,609.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	639,400.00	4,616,433.88
210204	Ажилгүйдлийн даатгал	520,687.00	1,105,557.78
210205	Эрүүл мэндийн даатгал	7,992,000.00	11,131,170.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,505,800.00	242,665,300.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	35,445,300.00
210302	Түлш, халаалт	00.00	20,870,200.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	672,400.00
210304	Байрны түрээс	98,505,800.00	185,677,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,535,945.72	57,076,215.26
210401	Бичиг хэрэг	10,000,000.00	13,893,055.00
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	9,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,333,545.72	18,860,740.26
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,474,300.00	2,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,228,100.00	12,832,420.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	102,469,473.00	6,065,230.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,776,000.00	1,757,280.00
210604	Урсгал засвар	77,693,473.00	4,307,950.00
2107	Томилолт, зочны зардал	21,626,162.00	4,225,000.00
210701	Гадаад албан томилолт	13,500,000.00	4,018,000.00
210702	Дотоод албан томилолт	8,126,162.00	207,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	433,426,680.00	189,571,699.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	361,031,280.00	95,439,043.42
210803	Даатгалын үйлчилгээ	2,850,400.00	2,986,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,300.00	165,476.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	58,795,000.00	81,079,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	14,800.00	15,780.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,545,900.00	9,852,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,540,000.00	14,838,023.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,851,250.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,540,000.00	11,986,773.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	198,847,044.64	37,983,018.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,260,000.00	16,821,895.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	131,260,000.00	5,976,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	10,845,895.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,587,044.64	21,161,123.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,635,903.94	17,861,123.30
213305	Төвлөрүүлэг шилжүүлэг /нэмэлт санхүүжилт/	39,951,140.70	3,300,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	171,171,780.00	547,378,129.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	168,320,500.00	526,193,729.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	168,320,500.00	526,193,729.00
2200	Дотоод эх үүсвэрээр	168,320,500.00	526,193,729.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	168,320,500.00	526,193,729.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-168,320,500.00	-526,193,729.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,851,280.00	21,184,400.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	2,851,280.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,851,280.00	24,035,680.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,255,061,400.00	1,767,948,700.25	487,112,699.75	78.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,255,061,400.00	1,767,948,700.25	487,112,699.75	78.4
210	Бараа, үйлчилгээний зардал	2,225,962,200.00	1,751,126,805.25	474,835,394.75	78.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	904,075,200.00	632,783,006.56	271,292,193.44	70.0
210101	Үндсэн цалин	594,507,200.00	429,212,183.56	165,295,016.44	72.2
210102	Нэмэгдэл	210,338,400.00	140,931,358.00	69,407,042.00	67.0
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	54,219,000.00	62,639,465.00	-8,420,465.00	115.5
210104	Урамшуулал	45,010,600.00	-	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,642,800.00	80,575,632.01	71,067,167.99	53.1
210201	Тэтгэврийн даатгал	106,711,200.00	80,575,632.01	26,135,567.99	75.5
210202	Тэтгэмжийн даатгал	11,233,200.00	-	-	-
210203	ҮОМШӨ ний даатгал	8,986,800.00	-	-	-
210204	Ажилгүйдлийн даатгал	2,246,400.00	-	-	-
210205	Эрүүл мэндийн даатгал	22,465,200.00	-	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	242,665,300.00	242,665,300.00	0.00	100.0
210301	Гэрэл цахилгаан	35,445,300.00	35,445,300.00	0.00	100.0
210302	Түлш, халаалт	20,870,200.00	20,870,200.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	672,400.00	672,400.00	0.00	100.0
210304	Байрны түрээс	185,677,400.00	185,677,400.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	68,297,300.00	57,920,015.26	10,377,284.74	84.8
210401	Бичиг хэрэг	13,939,600.00	13,893,055.00	46,545.00	99.7
210402	Тээвэр (шатахуун)	12,305,400.00	9,050,000.00	3,255,400.00	73.5
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	21,130,000.00	18,860,740.26	2,269,259.74	89.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,074,400.00	2,440,000.00	4,634,400.00	34.5

Оюуны өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	13,847,900.00	13,676,220.00	171,680.00	98.8
2106	Эд хогшил худалдан авах	266,856,500.00	215,342,130.00	51,514,370.00	80.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	262,546,700.00	211,034,180.00	51,512,520.00	80.4
210604	Урсгал засвар	4,309,800.00	4,307,950.00	1,850.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	17,577,400.00	4,225,000.00	13,352,400.00	24.0
210701	Гадаад албан томилолт	10,262,200.00	4,018,000.00	6,244,200.00	39.2
210702	Дотоод албан томилолт	7,315,200.00	207,000.00	7,108,200.00	2.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	558,334,900.00	505,628,948.42	52,705,951.58	90.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	441,390,000.00	411,512,072.42	29,877,927.58	93.2
210803	Даатгалын үйлчилгээ	2,986,800.00	2,986,800.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	190,600.00	165,476.00	25,124.00	86.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	74,000.00	33,000.00	41,000.00	44.6
210806	Мэдээллийн технологийн зардал	95,093,500.00	81,079,600.00	14,013,900.00	85.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,600,000.00	9,852,000.00	8,748,000.00	53.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,512,800.00	11,986,773.00	4,526,027.00	72.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,332,300.00	11,986,773.00	345,527.00	97.2
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,099,200.00	16,821,895.00	12,277,305.00	57.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,099,200.00	16,821,895.00	12,277,305.00	57.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,897,600.00	5,976,000.00	3,921,600.00	60.4
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,201,600.00	10,845,895.00	8,355,705.00	56.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,255,061,400.00	1,767,948,700.25	487,112,699.75	78.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	178,361,900.00	152,721,071.70	25,640,828.30	85.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	178,361,900.00	152,721,071.70	25,640,828.30	85.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,076,699,500.00	1,615,227,628.55	461,471,871.45	77.8
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,076,699,500.00	1,615,227,628.55	461,471,871.45	77.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,851,280.00	-2,851,280.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	59	47	12	79.8
620001	Удирдах ажилтан	5	5	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	54	42	12	77.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,300,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,300,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,300,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		3,300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3,300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,300,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Оюуны өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад актлагдсан хөрөнгийг устгах, анхан шатны баримтын бүрдэл, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ари файнэнс аудит ХХК-ийн ахлах аудитор Р.Мядагмаа, аудитор Г.Эрдэнэмөнх нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Долгорсүрэн, захирал Д.Ариунаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Оюуны өмчийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Ари Файнэнс аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/63 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Оюуны өмчийн газрын зорилго нь иргэдийн бүтээл туурвих, шинэ санаачилгыг дэмжиж, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлэн, оюуны өмчийн эрхийн хамгаалалт, хэрэгжилтийг хангах, ашиглалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг жишигт хүргэхэд оршино.

Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгаж сурталчлах, гадаад харилцаа хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх, аж үйлдвэрийн эрхийн маргаан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, ардын урлагийн бүтээлийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хамгаалалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж хэрэгжүүлэх, зохиогчийн эрхэд суурилсан аялал жуулчлал хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, шинэ бүтээл, ашигтай загвар, барааны тэмдэг, газар зүйн заалт, бүтээгдэхүүний загварын эрхийн хамгаалалт хүссэн мэдүүлгийг хүлээн авч бүрдлийн шүүлт, чанарын шүүлт хийх замаар шийдвэрлэх үйл ажиллагаа явуулах, аж үйлдвэрийн өмчийн улсын бүртгэл, бүртгэлийн дараах өөрчлөлт, лицензийн гэрээний бүртгэлийг хөтлөх, оюуны өмчийн зөрчлийн статистик мэдээ гаргах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ гаргах, зөрчлийг таслан зогсоох зэрэг чиг үүрэгтэй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол улсын барааны тэмдэг, газар зүйн тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 42 дугаар “Төлөвлөгөө батлах тухай” тогтоол
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ” тогтоол
- Засгийн газрын 151 дүгээр тогтоол / Оюуны өмчийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн А/105 тоот тушаалаар хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг баталж, мөрдөж эхэлсэн байна. Оюуны өмчийн газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны үр дүнг дүгнэхдээ байгууллагын санхүүгийн албаны үйл ажиллагааг батлагдсан төсвийн зарцуулалт, орлогын төвлөрүүлэлт, үнэт цаасны тооцоо бодолт, аудитын дүгнэлт, зөвлөмжийн биелэлт, төсвийн зарцуулалтын мэдээ, өмч хөрөнгийн тооллого хийсэн эсэх, ёс зүйн сахилга хариуцлага зэрэгт хяналт тавьж үнэлж, дүгнэдэг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын орон тоо байхгүй, дотоод хяналтын ажилтан ажилладаг тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Оюуны өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,577,722.8 мянган төгрөгөөс 1.0 хувь буюу 15,777.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Оюуны өмчийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 344,338.3 мянган төгрөгөөр буюу 33.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,851.3	24,035.7	21,184.4
Авлага	0	0	0

Урьдчилгаа	73,989.1	60.0	-73,929.1
Бараа материал	56,040.7	67,239.3	11,198.6
Үндсэн хөрөнгө	544,846.8	930,731.7	385,884.9
Нийт хөрөнгө	677,727.9	1,022,066.7	344,338.8
Өр төлбөр	0	0	0
Хуримтлагдсан үр дүн	677,727.9	1,022,066.7	344,338.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	677,727.9	1,022,066.7	344,338.8

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 24,035.7 мянган төгрөг болж, 21,184.4 мянган төгрөгөөр өссөн нь төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн орлогоос шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 67,239.3 мянган төгрөг болж, 11,198.6 мянган төгрөгөөр өссөн нь үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхийн тулд бичиг, хэргийн материал нөөцөлсөн, 7,168.7 мянган төгрөгийн хангамжийн материал бэлтгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс худалдаж авсан 452,360.4 мянган төгрөгийн тавилга, компьютерын дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын даргын 2021 оны А-1/894 дүгээр тушаалын дагуу акталсан 156,480.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Тайлант онд 73,833.3 мянган төгрөгийн биет бус хөрөнгө худалдан авч, ТӨБЗГ-ын даргын 2021 оны А-1/894 дүгээр тушаалын дагуу 190,438.5 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг акталсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,258,299.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,258,299.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,237.8 мянган төгрөгөөр бууруулж 2,255,061.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,255,061.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 178,361.9 мянган төгрөгийг улсын төсвөөс 2,076,699.5 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 152,721.1 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, батлагдсан төсвөөс 25,640.8 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,076,699.5 мянган төгрөг бүрдүүлэхээр төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 1,615,243.4 мянган төгрөгийн орлого бүрдэж, орлогын төлөвлөгөө 461,471.9 мянган төгрөгөөр тасарсан байна.

Тайлант онд 24,035.7 мянган төгрөгийн торгуулийн орлого бүрдүүлснийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,767,948.7 мянган төгрөг буюу 78.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 271,292.2 мянган төгрөгөөр, ажил

олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 71,067.2 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 10,377.3 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 51,514.4 мянган төгрөгөөр, гадаад, дотоод томилолтын зардлыг 13,352.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 52,690.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,674.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

			/мянган төгрөг/			
Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70428	Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт	2,255,061.4	1,767,948.7	487,112.7	78.4%
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,221,781.7	1,751,126.8	470,654.9	78.8 %
1.2	80305	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	4,180.5	-	4,180.5	0.0%
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	29,099.2	16,821.9	12,277.3	57.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Оюуны өмчийн газрын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,300.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг оны эцэст Сангийн яам татан төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Оюуны өмчийн газар нь тайлант онд 59 орон тоотой ажиллахаас 47 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 107 мэдээллээс 95 мэдээллийг хугацаанд нь, 134,837.0 мянган төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлж байх зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагад аудит хийх гэрээ нь 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байгуулагдсан тул завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснээс хэрэгжилт 50.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	31,739.4	1	-	1	31,739.4	50.0
Зөвлөмж	2	60.0	1	60.0	1	-	50.0
Нийт дүн	4	31,799.4	2	60.0	2	31,739.4	50.0

Хэрэгжүүлээгүй 1 зөвлөмжид албан шаардлага өгч, барагдуулаагүй 31,739.4 мянган төгрөгийн албан шаардлага хэрэгжих шатандаа байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 162,338.6 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс 19,922.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 142,415.7 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 162,338.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 11,832.9 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

4.1 Төлбөрийн акт

Анхан шатны баримтгүй 19,922.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил барагдуулах тухай төлбөрийн акт тогтоох

4.2 Албан шаардлага

1. Тус байгууллагад Зохиогчийн эрхийн хэлтсийн даргаар ажиллаж байсан ажилтанд тус газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн "Ажлаас халах тухай" тушаалыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардал нийт 31,739.4 мянган төгрөгийг нөхөж олгосныг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэж заасантай нийцээгүй, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах тухай албан шаардлага өгөх

2. Батлагдсан төсвөөс байгууллагын даргын тушаал, шийдвэргүйгээр 7,168.8 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэж зарцуулсан, Улсын тэмдэгтийн тухай хууль, Засгийн газрын 151 дүгээр тогтоол, шадар сайдын 2006 оны 59 дүгээр тушаалын дагуу төвлөрүүлдэг үйл ажиллагааны үндсэн орлогыг нягтлан бодох бүртгэлд төрлөөр нь ангилж бүртгээгүй, мэргэжилтнүүдэд олгосон үнэт цаасны тооцоо хийгдээгүй. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 “Зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал /цүнх, календарь, мэндчилгээ гэх мэт/-ын зардал гаргахгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд улирал, жилийн тайлан, тэнцэлд тусгаж тайлагнан:...3/ дуусаагүй үйлдвэрлэл, өөрийн үйлдвэрийн хагас боловсруулсан зүйл, үнэт цаасны тооллогыг улиралд 1 удаа/ улирлын эцсийн сарын 25-аас/” гэсэн заалтуудтай нийцээгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах тухай албан шаардлага өгөх

3. Санхүүгийн тайлан дахь урьдчилж төлсөн зардлын эхний 73,989.1 мянган төгрөгийн эхний үлдэгдлийг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрсөн ч гэрээт ажлын гүйцэтгэл, гэрээ дүгнэсэн акт, холбогдох үндсэн баримт материал шаардлага хангахгүй дутуу байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:...16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих.”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах тухай албан шаардлага өгөх

4. Анхан шатны баримтын бүрдэлгүй 3,060.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 26,458.1 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шаардаж бүрдүүлээгүй, татварын цахим хуудсанд и-баримтын шивэлтэд хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах тухай албан шаардлага өгөх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хэсэгчилсэн тооллого хийхэд өмнөх онуудад актлагдсан хөрөнгийг устгаагүй агуулахад хадгалсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т 3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахад дараахь журмыг баримтална: 3/ засаж сэлбэн

ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах;" заалттай нийцээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Өмч хамгаалах байнгын зөвлөл журамд заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэх, засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах дүгнэлт гаргаж, асуудлыг шийдвэрлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Оюуны өмчийн газар	АХГ-2022/337/НА-СТА-ТШЗ	Батлагдсан төсвөөс байгууллагын даргын тушаал, шийдвэргүйгээр бэлэг дурсгалд зарцуулсан.	Үр ашиггүй зардлыг хэмнэж, төсвийг зориулалтын дагуу зарцуулах	1	7,168.8					1	7,168.8		
2			Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч, бүртгэсэн байна.	Холбогдох албан тушаалтнаар төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх	1	19,922.9			1	19,922.9				
3			Тус байгууллагад "Зохиогчийн эрхийн хэлтсийн даргаар ажиллаж байсан ажилтныг тус газрын даргын 2018 оны "Ажлаас халах тухай" тушаалыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардлыг нөхөж олгосныг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.	Буруутай албан тушаалтнаар төрд учруулсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авах	1	31,739.4					1	31,739.4		

Оюуны өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Оюуны өмчийн газар	АХГ-2022/337/НА-СТА-ТШЗ	Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байх	Нэмэгдсэн өртгийн албан татварын цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас бүрдүүлэх, татварын цахим хуудсанд баримтын шивэлтийн хянах	1	29,518.4					1	29,518.4		
5	Оюуны өмчийн газар	АХГ-2022/337/НА-СТА-ТШЗ	2020 оны санхүүгийн тайланд тусгагдсан урьдчилж төлсөн зардлын эхний үлдэгдлийг 2021 онд зардлаар бүртгэж хаасан боловч ажлыг хүлээж авсан гүйцэтгэлийн акт, холбогдох үндсэн баримт материал шаардлага хангахгүй дутуу байна.	Гэрээт ажлыг гүйцэтгэсэн хуулийн этгээдээс ажлын гүйцэтгэлийн баримтыг бүрдүүлэх, гэрээг дүгнэж, акт үйлдэх	1	73,989.1					1	73,989.1		
6	Оюуны өмчийн газар	АХГ-2022/337/НА-СТА-ТШЗ	Улсын тэмдэгтийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Шадар сайдын 2006 оны 59 дүгээр тушаалын дагуу төвлөрүүлдэг үйл ажиллагааны үндсэн орлогыг нягтлан бодох бүртгэлдээ төрлөөр нь ангилж бүртгээгүй, мэргэжилтнүүдэд олгосон үнэт цаасны тооцоог хийдэггүй.	Үнэт цаасны тооллогыг улирал бүр хийж, баримтжуулах, үйл ажиллагааны үндсэн орлогыг нягтлан бодох бүртгэлд төрлөөр нь ангилан бүртгэх	1						1	-		
7	Оюуны өмчийн газар	АХГ-2022/337/НА-СТА-ТШЗ	Бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хэсэгчилсэн тооллого хийхэд урд онуудад актлагдсан хөрөнгийг устгаагүй агуулахад хадгалсан байна.	Зөвлөмж	1									
ДҮН					7	162,338.6			1	19,922.9	5	142,415.7	1	-

**Оюуны өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Оюуны өмчийн газар	АХГ-2022/337/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах мэдээллүүдийг хугацаа хоцроосон, дансны нэр буруу бичигдсэн, орлого, зарлагын дүн зөрүүтэй мэдээлэгдсэн зөрчлүүдийг аудит хийх хугацаанд залруулж байршуулсан.	Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлж байх зөвлөмж өгөх	1	134,837.0							1	134,837.0
ДҮН					1	134,837.0							1	134,837.0
НИЙТ ДҮН					8	297,175.6			1	19,922.9	5	142,415.7	2	134,837.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 14/20150055

Улаанбаатар хот

АХГ-2022/337/МА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Оюуны өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтгүй 19,922,923.00 төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн 19,922,923.00 (Арван есөн сая есөн зуун хорин хоёр мянга есөн зуун хорин гурав) төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Оюуны өмчийн газрын дарга Д.Элбэгсайхан, нягтлан бодогч Д.Отгонсүрэн нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.АРИУНАА

9006109
9019120396



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 50/20150055
АХГ-2022/337/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Оюуны өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Батлагдсан төсвөөс байгууллагын даргын тушаал, шийдвэргүйгээр 7,168,750.00 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэж, зарцуулсан.
2. Улсын тэмдэгийн тухай хууль, Засгийн газрын 151 дүгээр тогтоол, Шадар сайдын 2006 оны 59 дүгээр тушаалын дагуу төвлөрүүлдэг үйл ажиллагааны үндсэн орлогыг нягтлан бодох бүртгэлд төрлөөр нь ангилж бүртгээгүй, мэргэжилтнүүдэд олгосон үнэт цаасны тооцоог хийгээгүй.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "Зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал /цүнх, календарь, мэндчилгээ гэх мэт/-ын зардал гаргахгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 3/ дуусаагүй үйлдвэрлэл, өөрийн үйлдвэрийн хагас боловсруулсан зүйл, үнэт цаасны тооллогыг улиралд 1 удаа / улирлын эцсийн сарын 25-наас/" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үр ашиггүй зардлыг хэмнэж, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, үнэт цаасны тооллогыг улирал бүр хийж, баримтжуулах, үйл ажиллагааны үндсэн орлогыг нягтлан бодох бүртгэлд төрлөөр нь ангилан бүртгэж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Оюуны өмчийн газрын дарга Д.Элбэгсайхан, нягтлан бодогч Д.Отгонсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.АРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-70.Docx

001080230



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 49/20250055
АХГ- 2020/337/НА-СТА тцз

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Оюуны өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 3,060,314.00 төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 26,458,153.00 төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шаардаж бүрдүүлээгүй, татварын цахим хуудсанд и-баримтын шивэлтэд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 "албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үр ашиггүй зардлыг хэмнэж, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, нэмэгдсэн өртгийн албан татварын цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шаардаж, бүрдүүлэх, татварын цахим хуудсанд баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Оюуны өмчийн газрын дарга Д.Элбэгсайхан, нягтлан бодогч Д.Отгонсүрэн нарт даалгав.
- 3.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
ДАРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250

\\0.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-69.Docx

001080227



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 48/2022/0055

Улаанбаатар хот

АХГ- 2022/337/НА-СТ-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Оюуны өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагад Зохиогчийн эрхийн хэлтсийн даргаар ажиллаж байсан ажилтанд Оюуны өмчийн газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн "Ажлаас халах тухай" тушаалыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардал нийт 31,739,400.00 төгрөгийг нөхөн олгосныг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Буруутай албан тушаалтнаар төрд учруулсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Оюуны өмчийн газрын дарга Д.Элбэгсайхан, нягтлан бодогч Д.Отгонсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.АРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-68.Docx

001080224



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 47/А0150055
АХГ-2022/337/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Оюуны өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлан дахь урьдчилж төлсөн зардлын 73,989,073.00 төгрөгийн эхний үлдэгдлийг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрсөн ч гэрээт ажлын гүйцэтгэл, гэрээ дүгнэсэн акт, холбогдох үндсэн баримт материал шаардлага хангахгүй дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5. "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ... 16.5.2. батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээт ажлыг гүйцэтгэсэн хуулийн этгээдээс ажлын гүйцэтгэлийн баримтыг бүрдүүлэх, гэрээг дүгнэж, акт үйлдэх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Оюуны өмчийн газрын дарга Д.Элбэгсайхан, нягтлан бодогч Д.Отгонсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Д.АРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

\\16.10.10.20\Bichig_Kherag\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-67.Docx

901080221